**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2024/07-НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа |
| | Утас:7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn |
| Сүхбаатар сум | Аудитын менежер: Б.Батмөнх |
| 2024 он | Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn |
| | Ахлах аудитор: Ц.Отгонбаяр |
| | Утас: 7036-3047 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын дүгнэлт 3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 5-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга 11-15
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 11
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 11-12
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 12
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 12-13
   3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 13-15
4. Аудитын тайлан 15-17
   4.1 Ерөнхий зүйл 15
   4.2 Материаллаг байдал 15
   4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 15-16
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 16
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 16
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 17
5. Аудитын илрүүлэлт 17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл 18-19


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ТӨХК | Төрийн өмчит хувьцаат компани |
| ШЕЗ | Шүүхийн Ерөнхий зөвлөл |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН
МАНДАЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.БАТСАЙХАН ТАНАА

2024.02.08 № СЭА-2024/07-НА-СТА-Т4/3
танай ______-ны № ______-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноос голлон шалтгаалж тус газрын 2023 оны нийт зардал өмнөх оноос 29.8 хувиар нэмэгдсэн байна.

Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон

Шүүгчдийн орон сууцны түрээсийн төлбөрт 2,880.0 мянган төгрөгийг төлөвлөж, баталсан боловч "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК нь байгууллагатай бус хувь хүнтэй гэрээ байгуулж, түрээсийн төлбөрийг хувь хүнээс нэхэмжлэн төлүүлснээс

018020001

шалтгаалж, дээрх зардлаас 1,832.1 сая төгрөгийг бусад тогтмол зардалд гүйлгэн зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлийг үндэслэн 22 албан хаагчид ажлын үр дүнг харгалзан, албан тушаалын үндсэн цалингаар тооцож, 34,994.8 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

ШЕЗ-өөс өгсөн чиглэлийн дагуу цалингийн зардлын хэмнэлтээс 6,000.0 мянган төгрөгийг Төрийн сан дахь "Ахмадын сан"-гийн 100130405501 дугаар дансанд төвлөрүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 74 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 29,343,157.25 | 29,178,671.25 |
| 31 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 1,000,000.00 | 6,000,000.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 1,000,000.00 | 6,000,000.00 |
| 3121 | Төгрөг | 1,000,000.00 | 6,000,000.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 1,000,000.00 | 6,000,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **28,343,157.25** | **23,178,671.25** |
| 354 | Хангамжийн материал | 28,343,157.25 | 23,178,671.25 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,886,164.00 | 2,219,190.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 25,135,556.25 | 19,712,776.25 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 1,321,437.00 | 1,246,705.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **730,121,967.97** | **704,181,334.05** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **730,121,967.97** | **704,181,334.05** |
| **392** | **Биет хөрөнгө** | **666,223,218.06** | **640,407,584.18** |
| 39201 | Барилга, байгууламж | 595,724,204.08 | 595,724,204.08 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (62,164,466.88) | (77,705,583.60) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 116,495,000.00 | 116,495,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (25,278,333.39) | (37,811,666.79) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 148,879,925.56 | 156,049,435.56 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (118,892,574.60) | (129,143,169.09) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 52,250,199.00 | 63,430,199.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (44,299,183.22) | (49,902,296.85) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,810,058.07 | 4,810,058.07 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,747,942.56) | (2,184,928.20) |
| 39217 | Номын фонд | 446,332.00 | 646,332.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **63,898,749.91** | **63,773,749.87** |
| 39301 | Программ хангамж | 1,050,000.00 | 1,050,000.00 |
| 39302 | Хасагдуулга | (831,250.09) | (956,250.13) |
| 39303 | Газар эзэмших эрх | 63,680,000.00 | 63,680,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **759,465,125.22** | **733,360,005.30** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **-** | **769,885.01** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 769,885.01 |
| 413 | Өглөг | - | 769,885.01 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 769,885.01 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **759,465,125.22** | **732,590,120.29** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 759,465,125.22 | 732,590,120.29 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 178,942,622.54 | 178,942,622.54 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 178,942,622.54 | 178,942,622.54 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (53,853,520.36) | (80,728,525.29) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (72,870,431.48) | (53,853,520.36) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 19,016,911.12 | (26,875,004.93) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 634,376,023.04 | 634,376,023.04 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **759,465,125.22** | **733,360,005.30** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **728,461,017.25** | **893,911,510.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **48,358,717.25** | **15,787,110.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 45,495,279.00 | 15,787,110.00 |
| 120009 | Бусад орлого | 38,779,749.00 | 848,200.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 4,701,210.00 | 12,625,610.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 2,014,320.00 | 2,313,300.00 |
| 122 | Тусламжийн орлого | 2,863,438.25 | - |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 2,863,438.25 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **680,102,300.00** | **878,124,400.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 680,102,300.00 | 878,124,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 680,102,300.00 | 878,124,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **709,426,229.05** | **920,786,514.93** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **709,426,229.05** | **920,786,514.93** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **690,367,391.06** | **908,289,508.38** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **504,015,432.01** | **668,342,899.99** |
| 210101 | Цалин | 335,426,129.80 | 431,394,898.73 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 133,705,199.21 | 148,436,223.12 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,329,375.00 | 23,998,864.95 |
| 210104 | Урамшуулал | 22,554,728.00 | 64,512,913.19 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **63,058,792.00** | **83,423,387.01** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 42,879,982.00 | 56,779,437.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 5,044,702.00 | 6,679,933.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,035,761.00 | 5,344,247.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1,008,940.00 | 1,329,069.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 10,089,407.00 | 13,290,701.01 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **34,699,968.00** | **42,756,962.65** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 4,158,145.00 | 5,627,655.38 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 28,659,479.00 | 35,824,411.27 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 1,882,344.00 | 1,304,896.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **28,599,649.00** | **33,710,630.81** |
| 210401 | Бичиг хэргийн материал | 11,631,548.00 | 10,131,474.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 8,205,661.00 | 10,551,681.00 |
| 210403 | Шуудан холбоо интернэтийн төлбөр | 5,814,140.00 | 6,272,325.81 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 190,000.00 | 238,000.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 2,758,300.00 | 6,517,150.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **18,538,470.00** | **20,244,380.00** |
| 210601 | Багаж хэрэгсэл | 560,000.00 | 8,244,380.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,978,470.00 | 12,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,745,600.00** | **7,541,700.00** |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 3,745,600.00 | 7,541,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж** | **4,907,660.00** | **6,779,404.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,030,000.00 | 3,852,569.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 2,678,000.00 | 2,655,925.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 136,860.00 | 163,230.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 44,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 18,800.00 | 63,680.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **32,801,820.05** | **45,490,143.92** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 1,000,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 32,801,820.05 | 44,490,143.92 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **19,058,837.99** | **12,497,006.55** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 750,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | - | 750,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 19,058,837.99 | 11,747,006.55 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,058,837.99 | 11,747,006.55 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **19,034,788.20** | **(26,875,004.93)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | **17,877.08** | **-** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 17,877.08 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)** | **(17,877.08)** | **-** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)** | **19,016,911.12** | **(26,875,004.93)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **681,102,300.00** | **884,124,400.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,000,000.00** | **6,000,000.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,000,000.00 | 6,000,000.00 |
| 120009 | Бусад орлого | 1,000,000.00 | 6,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **680,102,300.00** | **878,124,400.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 680,102,300.00 | 878,124,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 680,102,300.00 | 878,124,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **680,102,300.00** | **873,200,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **680,102,300.00** | **873,200,500.00** |
| **210** | **БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **661,043,462.01** | **860,703,493.45** |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 504,015,432.01 | 674,342,899.99 |
| 210101 | Үндсэн цалин | 335,426,129.80 | 437,394,898.73 |
| 210102 | Нэмэгдэл | 133,705,199.21 | 148,436,223.12 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,329,375.00 | 23,998,864.95 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 22,554,728.00 | 64,512,913.19 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **63,058,792.00** | **82,653,502.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 42,879,982.00 | 56,779,437.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 5,044,702.00 | 6,679,933.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,035,761.00 | 5,344,247.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1,008,940.00 | 1,259,080.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 10,089,407.00 | 12,590,805.00 |
| **2103** | **Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал** | **34,699,968.00** | **42,756,962.65** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 4,158,145.00 | 5,627,655.38 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 28,659,479.00 | 35,824,411.27 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 1,882,344.00 | 1,304,896.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **29,160,040.00** | **30,353,024.81** |
| 210401 | Бичиг хэрэг | 10,558,500.00 | 10,151,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,450,000.00 | 9,628,749.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,814,140.00 | 6,272,325.81 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 190,000.00 | 238,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,147,400.00 | 4,062,950.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **20,455,970.00** | **15,276,000.00** |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 2,477,500.00 | 3,276,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,978,470.00 | 12,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,745,600.00** | **7,541,700.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,745,600.00 | 7,541,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,907,660.00** | **6,779,404.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 2,030,000.00 | 3,852,569.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,678,000.00 | 2,655,925.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 136,860.00 | 163,230.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 44,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 18,800.00 | 63,680.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,000,000.00** | **1,000,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **19,058,837.99** | **12,497,006.55** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 750,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | - | 750,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 19,058,837.99 | 11,747,006.55 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,058,837.99 | 11,747,006.55 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **1,000,000.00** | **10,923,900.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **-** | **5,923,900.00** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 5,923,900.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 5,923,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 5,923,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-** | **(5,923,900.00)** |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **1,000,000.00** | **5,000,000.00** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | (0.00) | 1,000,000.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,000,000.00 | 6,000,000.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| КОД | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| | ДАНС | 511 | 51300 | 51210+51220 | |
| **C01** | **2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл** | **178,942,622.54** | **634,376,023.04** | **(72,870,431.48)** | **740,448,214.10** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **178,942,622.54** | **634,376,023.04** | **(72,870,431.48)** | **740,448,214.10** |
| C04 | Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | - | - | - | - |
| C05 | Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 19,016,911.12 | 19,016,911.12 |
| **C08** | **2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **178,942,622.54** | **634,376,023.04** | **(53,853,520.36)** | **759,465,125.22** |
| **D01** | **2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **178,942,622.54** | **634,376,023.04** | **(53,853,520.36)** | **759,465,125.22** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **178,942,622.54** | **634,376,023.04** | **(53,853,520.36)** | **759,465,125.22** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | (26,875,004.93) | (26,875,004.93) |
| **D09** | **2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **178,942,622.54** | **634,376,023.04** | **(80,728,525.29)** | **732,590,120.29** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - | - | - |
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **878,208,100.00** | **866,377,393.45** | **11,830,706.55** | **98.65** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **878,208,100.00** | **866,377,393.45** | **11,830,706.55** | **98.65** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | **877,208,100.00** | **865,627,393.45** | **11,580,706.55** | **98.68** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **674,428,000.00** | **674,342,899.99** | **85,100.01** | **99.99** |
| 210101 | Үндсэн цалин | 461,684,200.00 | 437,394,898.73 | 24,289,301.27 | 94.74 |
| 210102 | Нэмэгдэл | 148,326,100.00 | 148,436,223.12 | (110,123.12) | 100.07 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 32,181,600.00 | 23,998,864.95 | 8,182,735.05 | 74.57 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 32,236,100.00 | 64,512,913.19 | (32,276,813.19) | 200.13 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **82,676,700.00** | **82,653,502.00** | **23,198.00** | **99.97** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,279,400.00 | 56,779,437.00 | 2,499,963.00 | 95.78 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,849,300.00 | 6,679,933.00 | (830,633.00) | 114.20 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 4,679,500.00 | 5,344,247.00 | (664,747.00) | 114.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,169,900.00 | 1,259,080.00 | (89,180.00) | 107.62 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,698,600.00 | 12,590,805.00 | (892,205.00) | 107.63 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **43,804,900.00** | **42,756,962.65** | **1,047,937.35** | **97.61** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 4,562,200.00 | 5,627,655.38 | (1,065,455.38) | 123.35 |
| 210302 | Түлш, халаалт | 35,715,500.00 | 35,824,411.27 | (108,911.27) | 100.30 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 647,200.00 | 1,304,896.00 | (657,696.00) | 201.62 |
| 210304 | Байрны түрээс | 2,880,000.00 | - | 2,880,000.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **38,116,600.00** | **30,553,024.81** | **7,563,575.19** | **80.16** |
| 210401 | Бичиг хэрэг | 11,500,000.00 | 10,151,000.00 | 1,349,000.00 | 88.27 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 9,629,400.00 | 9,628,749.00 | 651.00 | 99.99 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 10,277,200.00 | 6,272,325.81 | 4,004,874.19 | 61.03 |
| 210404 | Ном, хэвлэл | 600,000.00 | 200,000.00 | 400,000.00 | 33.33 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 960,000.00 | 238,000.00 | 722,000.00 | 24.79 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 5,150,000.00 | 4,062,950.00 | 1,087,050.00 | 78.89 |
| **2105** | **Нормативт зардал** | **500,000.00** | **-** | **500,000.00** | **-** |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 500,000.00 | - | 500,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил худалдан авах** | **21,000,000.00** | **20,999,900.00** | **100.00** | **100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,000,000.00 | 8,999,900.00 | 100.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,000,000.00 | 12,000,000.00 | - | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **9,761,300.00** | **7,541,700.00** | **2,219,600.00** | **77.26** |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,761,300.00 | 7,541,700.00 | 2,219,600.00 | 77.26 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **6,870,600.00** | **6,779,404.00** | **91,196.00** | **98.67** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,900,000.00 | 3,852,569.00 | 47,431.00 | 98.78 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,678,000.00 | 2,655,925.00 | 22,075.00 | 99.18 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 184,800.00 | 163,230.00 | 21,570.00 | 88.33 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 44,000.00 | - | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 63,800.00 | 63,680.00 | 120.00 | 99.81 |
| **2209** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **50,000.00** | **-** | **50,000.00** | **-** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 50,000.00 | - | 50,000.00 | - |
| | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,000,000.00** | **750,000.00** | **250,000.00** | **75.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,000,000.00 | 750,000.00 | 250,000.00 | 75.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 1,000,000.00 | 750,000.00 | 250,000.00 | 75.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **878,208,100.00** | **866,377,393.45** | **11,830,706.55** | **98.65** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **878,208,100.00** | **866,377,393.45** | **11,830,706.55** | **98.65** |
| **131001** | **Улсын төсвөөс санхүүжих** | **878,208,100.00** | **866,377,393.45** | **11,830,706.55** | **98.65** |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 0.00 | (0.00) | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 0.00 | (0.00) | - |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **-** | **-** | **-** | **-** |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | | **23.00** | **23.00** | **-** | **100.00** |
| 620001 | Удирдах ажилтан | | 2.00 | 2.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | | 17.00 | 17.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | | 4.00 | 4.00 | - | 100.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | | **23.00** | **23.00** | **-** | **100.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч /ТЗ/ | | 9.00 | 9.00 | - | 100.00 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч /ТТ/ | | 4.00 | 4.00 | - | 100.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/ | | 10.00 | 10.00 | - | 100.00 |

4317143998
МЮА0065 9055

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар / *Мандал сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар* / нь "*Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, шүүхийн үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй хүргэх*" гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах, шүүхийн хүний нөөц, шүүхийн судалгаа, мэдээлэл, олон нийтийг мэдээллээр хангах зэрэг хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Шүүхийг өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангах,
- Шүүхийн хөдөлмөр зохион байгуулалт, дотоод журмын биелэлтэд хяналт тавих,
- Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх,
- Шүүхийн бичиг хэрэг, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг зохион байгуулах,
- Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах,
- Хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Шүүхийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Мандал сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ШЕЗ-ийн Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албанаас хяналт тавьдаг бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ШЕЗ-ийн даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 174 дүгээр тушаалаар ШЕЗ-ийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Мандал сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26,105.1 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,000.00 | 6,000.00 | 5,000.00 |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 28,343.15 | 23,178.67 | (5,164.48) |
| Үндсэн хөрөнгө | 730,121.97 | 704,181.33 | (25,940.64) |
| **Нийт хөрөнгө** | **759,465.12** | **733,360.00** | **(26,105.12)** |
| Өр төлбөр | - | 769.88 | 769.88 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 759,465.12 | 732,590.12 | (26,875.00) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **759,465.12** | **733,360.00** | **(26,105.12)** |

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл нь 6,00.0 мянган төгрөг болж, 5,000.0 мянган төгрөгөөр өссөн нь ШЕЗ-өөс өгсөн чиглэлийн дагуу цалингийн зардлын хэмнэлтээс 6,000.0 мянган төгрөгийг төрийн сан дахь “Ахмадын сан”-гийн 100130405501 тоот дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 704,181.3 мянган төгрөг болж, 25,940.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 5,923.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ном худалдан авч, ШЕЗ-өөс 1,445.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 11,180.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг үнэ төлбөргүйгээр тус тус орлого авч, 44,490.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулсан нь нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 992,115.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 236,504.1 мянган төгрөгөөр бууруулж / *эд хогшил, урсгал засварын зардлыг 238,200.0 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 7,054.9 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 5,700.0 мянган төгрөгөөр хангамж, бараа материалын зардлыг 4,720.2 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 4,202.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 2,356.3 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 2,112.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, цалин,*

*ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 27,842.0 мянган төгрөгөөр өсгөсөн байна./* 755,611.8 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг нийт 122,596.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн тодотгол хийж, 878,208.1 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- *Цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 99,056.8 мянган төгрөгөөр,*
- *Тогтмол зардлыг 10,115.5 мянган төгрөгөөр,*
- *Эд хогшил, урсгал засварын зардлыг 8,000.0 мянган төгрөгөөр,*
- *Томилолтын зардлыг 5,964.0 мянган төгрөгөөр,*
- *Хангамж, бараа материалын зардлыг 965.0 мянган төгрөгөөр,*
- *Бараа үйлчилгээний бусад зардлыг 50.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,*
- *Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 1,555.0 мянган төгрөгөөр бууруулсан гэх мэт.*

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 878,208.1 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 878,124.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 865,627.4 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 11,830.7 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 877,208.10 | 865,627.40 | 11,580.70 | 98.68 |
| 2 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 1,000.00 | 750.00 | 250.00 | 75.00 |
| | **Дүн** | **878,208.10** | **866,377.40** | **11,830.70** | **98.65** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130405401 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мандал сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 709,426.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,094.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллага нь тайлант онд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж, бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг хэмнэсэн,
- Шүүхийн танилцуулга, боршур зэрэг тараах материал хэвлэх зардлыг зогсоосон,
- Ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувилал, төрсөн нутагтаа амрах тохиолдолд очих, ирэх замын зардлыг олгоогүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,

- Цахилгааны зардлыг хэмнэхийн тулд өдөр, шөнийн тарифаар бодогддог тоолуур тавиулсан, бохир соруулдаг байсныг нэгдсэн шугамд холбож, тогтмол зардлыг хэмнэж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Мандал сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын мэдээлбэл зохих 28 төрлийн 168 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодогчид үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын урамшуулал олгосон зөрчилд зөвлөмж өгснийг дахин давтан гаргаагүй байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 1,595.3 | 1 | 1,595.3 | 100 |
| **Нийт дүн** | **1** | **1,595.3** | **1** | **1,595.3** | **100** |

4317143998
МЮА0065 9055436

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 6769.8 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 769.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 6,000.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

### 5.1 Албан шаардлага

1.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас НДШ-ийн 769.8 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Төлбөр тооцоо, гүйлгээг гарахаас өмнө нь хянан баталгаажуулж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, өр төлбөрийг барагдуулах албан шаардлага хүргүүлэх.

### 5.2 Зөвлөмж

**1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал:**

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь *"... байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах......"*, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 1.3 дахь "*Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана*" *гэсэн* заалтын дагуу Ахмадын сангийн эх үүсвэрийг төсөвт тусган төлөвлөөгүйгээс жилийн эцэст цалингийн зардлаас **6,000.0** мянган төгрөгийг төрийн сан дахь *"Ахмадын сан"*-ийн 100130405501 дугаар дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх *"Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална"*, 5.1.2 дахь *"Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

*2.2* <u>*Өгсөн зөвлөмж:*</u> Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалтыг хэрэгжүүлэн тухайн жилийн төсвийн төлөвлөгөөнд *"Ахмадын сан"*-ийн зардлыг тусган, батлуулах.

---

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5[2] дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаал-тны тоо | Тоо | Дүн |
| НДШ-ийн өглөг үүсгэсэн | 1 | 769.8 | | | 1 | 769.8 | | | | | | |
| Ахмадын санд шаардагдах хөрөнгийг төлөвлөөгүй | 1 | 6,000.0 | | | | | 1 | 6,000.0 | | | | |
| **Дүн** | **1** | **6,769.8** | | | **1** | **769.8** | **1** | **6,000.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |

[2] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 08 өдөр Дугаар 01/А 18 6 0 3 8 8 Сүхбаатар
СЭА-2024/07/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас НДШ-ийн 769.8 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *"Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;"* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох"* журмын 4.2.1-д *"Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана"*, 4.2.1.11 *"Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн..."* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар өр төлбөр үүсгэхгүй ажиллаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын дарга Д.Батсайхан, нягтлан бодогч Л.Сансугар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

АХЛАХ АУДИТОР Ц.ОТГОНБАЯР

СЭА-2024/07/НА-СТА-ТШЗ

018040002